

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СЯ	Сангийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУХС	Монгол Улсыг хөгжүүлэх сан
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.04.05 № 06/681
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сангийн Гүйцэтгэх захирал В.Үнэнбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно. Үүнд:

- Өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулж, барагдуулах;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудын дагуу санхүүгийн тайланг бүртгэх талаар тус тус зөвлөмж өгсөн.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Засгийн газрын тусгай сан нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 3 дугаар сарын 5-наас 2019 оны 3 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Тариалан эрхлэлтийг дэмжих санд хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын Ахлах аудитор Р.Цолмон хариуцаж хэрэгжүүлэв.

Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 04/07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Гэвч тус сан аудитын явцад удаан хугацаагаар аудитын залруулга бичилтийг санхүүгийн тайланд хэд хэдэн удаа залруулж, Сангийн яамтай тооцоо нийлээгүйгээс хугацаа их алдаж, аудитад хүндрэл учруулж, сүүлийн санхүүгийн тайланг 2019 оны 4 дүгээр сарын 5-нд Үндэсний аудитын газарт ирүүлснээс аудитын дүгнэлт өгөх хугацаа хоцорсон болно.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн эрхэм зорилго нь Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогын удирдамж, үндсэн чиглэл, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг бүрдүүлж, хуваарилах замаар үр тарианы үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино гэж тодорхойлжээ.

"Тариалангийн тухай" хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2005 оны 139 дүгээр тогтоолоор "Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам"-ыг батлан 2005 оны 6 дугаар сараас эхлэн Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэд "Тариалан эрхлэлтийг дэмжих сан"-г байгуулсан байна. Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн эрх барих дээд байгууллага нь Удирдах зөвлөл

бөгөөд сан нь одоо бие даасан ажлын алба, харьяа 6 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.17-д “Засгийн газрын тусгай сангийн захирагч тухайн сангийн төсвийн” гэж заасны дагуу тус сангийн захирал төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

“Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-д Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь доорх чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж заасан байна. Үүнд:

- Үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх,
- Тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн удирдлага Засгийн газрын тусгай сангийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Тариалангийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Axplorer” програм хангамж ашигладаг байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

ТЭДС-гийн Тамгын хэлтсийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн мэргэжлийн бус бөгөөд тайлант онд тус сангийн санхүүгийн бүртгэлийн хөрөнгө, нөөцийн өөрчлөлт хөдөлгөөн, ашиглалт зарцуулалт, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, найдвартай байдалд хяналт тавиагүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад, дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2 хувиар сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар материаллаг байдлын суурийг сонгосон нь тоон болон шинж чанарын хувьд материаллаг гэж үзэн нийт зардалд тус сангийн тариалан эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэгийн зарцуулалт хамаарагдаж байгаа гэж дүгнэснээс шалтгаалсан.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны нийт зардал 14,766.8 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 295.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 9 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөг)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	278.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.0	
3	Албан шаардлага өгсөн	3	10,474.3	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.0	
	Дүн	4	10,752.3	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Аудитын явцад хийсэн залруулга

- ТЭДС-гийн 2018 оны санхүүгийн тайланг СЯ-тай тооцоо нийлж, дахин баталгаажуулсан;
- ТЭДС-гийн Дархан салбарын 81.9 сая төгрөгийн Nissan patrol машиныг тус сангийн санхүүгийн тайланд, 11,285.0 сая төгрөгийн барилга байгууламжийг Хөтөл салбарын санхүүгийн тайланд бүртгэсэн;
- Бусад биет бус хөрөнгөд бүртгэсэн 1,647.9 сая төгрөгийн газрыг хорогдуулан залруулсан;
- Дархан-Уул аймгийн Ургамал, газар тариалангийн хүрээлэнд хүлээлгэн өгсөн нийт 683.3 сая төгрөгийн үрийн аж ахуйн зориулалттай иж бүрдлийг бараа материалын дансанд бүртгэж, зарлагдсан;

- ТЭДС нийт 182.3 мянган м.кв газар эзэмших эрхийн гэрчилгээтэй боловч газрын дахин үнэлгээг 5.3 мянган м.кв буюу 92.0 сая төгрөгөөр илүү үнэлж, нягтлан шалгалт хийлгэснийг аудитын явцад залруулав;
- ЗГ-ын 2016 оны 193 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээ”, ТӨБЗГ-ын 2018 оны 273 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолуудын дагуу тус сан нь 187.6 мянган м.кв газрын эзэмших эрхийн бодит үнэ цэнийг 9,743.7 сая төгрөгөөр, 37 ширхэг барилгын бодит үнэ цэнийг 6,747.9 сая төгрөгөөр тус тус үнэлснийг аудитын явцад ТӨБЗГ-аар хянан баталгаажуулав.

2.8.1.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: ТЭДС-гийн 2018 оны санхүүгийн тайланд нийт 135,069.8 сая төгрөгийн өглөг тусгаснаас 0.8 хувь буюу 1,160.7 сая төгрөгийн урамшууллын эргэн төлөлтийг СЯ-тай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж, аудитын “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1,160.7 сая төгрөгийг СЯ-тай тооцоо нийлж баталгаажуулах талаар албан шаардлага өгөх.

Илрүүлэлт 2: Тус сан 2017 онд ОХУ-ын техник, тоног төхөөрөмжийг урьдчилгаа төлбөргүйгээр Баянхонгор аймгийн ЗДТГ, Ховд аймгийн Дарви сумын ЗДТГ-уудтай тус тус гэрээ байгуулж, тухайн байгууллагуудаас тайлант хугацаанд төлөгдөх 41.6 мянган ам.доллар буюу 110.1 сая төгрөгийг барагдуулж, төлүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Баянхонгор аймгийн ЗДТГ, Ховд аймгийн Дарви сумын ЗДТГ-уудаас 110.1 сая төгрөгийн төлбөрийг барагдуулах арга хэмжээ авах талаар албан шаардлага өгөх.

Илрүүлэлт 3: ТЭДС-гийн 2018 оны санхүүгийн тайланд тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор олгосон нийт 117,170.3 сая төгрөгийн авлагаас 5.6 хувь буюу 6,506.1 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, 30.8 хувь буюу 36,079.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагууд байна.

Хугацаа хэтэрсэн нийт 36,079.4 сая төгрөгийн авлагын 2,697.4 сая төгрөг нь 1999-2014 оны хооронд үүссэн зээлийн гэрээний хугацаа дууссан, эзэн холбогдогч нь тодорхойгүй жимс, жимсгэнэ, чацаргана суулгацын авлага, 9,531.2 сая төгрөг нь шүүхэд шилжүүлсэн, 23,850.8 сая төгрөг нь гурилын үйлдвэр болон тариаланчдын авлагыг шүүхийн шийдвэр гаргуулж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгдэж байгаа авлагууд тус тус эзэлж байна.

Энэ нь Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн

заалтуудыг тус тус зөрчиж, аудитын “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 6,506.1 сая төгрөгийн авлагыг баталгаажуулах, 2,697.4 сая төгрөгийн жимс, жимсгэнэ, чацаргана суулгацын авлагыг барагдуулах, хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх талаар албан шаардлага өгөх.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2.9.1 Анхаарал татахуйц доорх асуудлууд байна.Үүнд:

- ХХААХҮС-ын 2018 оны А/30, ТЭДС-гийн гүйцэтгэх захирлын 2018 оны А/15 дугаар тушаалуудаар ТЭДС-гийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн баталснаар тус сангийн Дархан салбарыг татан буулгаж, эд хөрөнгө, бараа материалыг Төв болон Хөтөл салбарт шилжүүлэн олгосон байна,
- Тус сан Атрын 3 дахь аяны хүрээнд 2008 онд Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 80.9 мянган тонн улаан буудайны улсын төсөвт төвлөрүүлэх ёстой 27,311.1 сая төгрөгийн төлбөрийг Сангийн яамтай 21,053.5 сая төгрөгөөр тооцоо нийлж, баталгаажуулж, тайлант онд улсын төсөвт 704.2 сая төгрөгийг барагдуулсан байна,
- Сангийн яам болон ХХААХҮЯ хооронд 2017 онд байгуулсан үрийн улаанбуудай худалдан авахад зориулсан 23,400.0 сая төгрөгийн төсвийн зээлийг тайлант онд барагдуулсан байна,
- Сангийн сайд Ч.Хүрэлбаатарын 2019 оны 1 дүгээр сард баталсан удирдамжийн дагуу ТЭДС-гийн үүсгэн байгуулагдсанаас хойш онуудын санхүүгийн үйл ажиллагаанд СЯ-ны Санхүүгийн бодлогын газраас хяналт шалгалт хийсэн байна.

2.9 2. Тус сангийн тайлант хугацааны санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгөд 1,970.4 сая төгрөгийн ашиглагдахгүй байгаа машин, техник тоног төхөөрөмж бүртгэлтэй байна. Иймд дээрх хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр баталгаажуулан холбогдох газарт нь хандан шийдвэрлүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

2.9.3 Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан тайлант оны худалдан авах үйл ажиллагаа болон нийт авлага, өглөгийн эргэн төлөлт, гэрээний дагуу хугацаандаа хэрэгжсэн эсэхийг бүрэн тулгалт хийж чадаагүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын тусгай сан нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 8 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 17,166.7 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг 17,166.6 сая төгрөгөөр баталсан боловч МУХС-гаас олгосон зээл

24,000.0 сая, СЯ-наас үрийн улаанбуудай худалдан авахад зориулан олгосон төсвийн зээл 23,400.0 сая, тариалан эрхлэгчдэд олгох дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлт 25,400.0 сая төгрөгийг тус тус хорогдуулан тооцсоныг нэмэгдүүлбэл төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 40,636.4 сая төгрөгийн хэмнэлттэй зпарцуулсан байна.

Тайлант онд Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангаар үндсэн үйл ажиллагааны орлогоор 19,685.8 сая, туслах үйл ажиллагааны орлогоор 8,631.9 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 72.3 сая, нийт 28,390.0 сая төгрөгийн орлогыг тус тус олсон байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоонд хангах хүрээнд тус сан өөрийн цахим хуудсаар <http://mofa.gov.mn> байршуулсан байна.

Тус сангийн Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу албан тушаалтан хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа эсэхийг аудитаар анхаарч үзлээ. Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн шилэн дансны сайтад бүрэн хамрагдсан бөгөөд шилэн дансны цахим хуудсанд 2018 онд орлогын 47,380.6 сая төгрөгийн 586 мэдээлэл, зарлагын 51,657.2 сая төгрөгийн 484 мэдээллийг тус тус байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

ТЭДС-гийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 486.7 сая төгрөгийн 1 зөвлөмж өгснөөс 99.1 хувийн биелэлттэй байна. Тухайлбал:

Хэрэгжих шатандаа байгаа зөвлөмж:

- Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 486.7 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах талаар зөвлөмж өгснийг аудитын явцад дахин шалгахад 99.1 хувийн биелэлттэй байна.

ТЭДС-гийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 42,103.0 сая төгрөгийн 2 албан шаардлага өгснөөс 1 албан шаардлага биелэгдэж, 1 албан шаардлага хэрэгжих шатандаа, 2,000.0 сая төгрөгийн акт тогтоосноос 5.0 хувийн биелэлттэй байна. Тухайлбал:

шатандаа байгаа албан шаардлага:

- Урьдчилж орсон орлого дансанд 561.3 сая төгрөг бүртгэсэн ба юуны орлого болох нь тодорхойгүйгээс тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Хэрэгжих шатандаа байгаа акт:

- Атрын 3 дахь аяны хүрээнд 2008 онд Монгол Улсыг хөгжүүлэх сангаас авсан 80.9 мянган тонн улаан буудайн өглөгөөс барагдуулах талаар акт тогтоосноос 100.0 сая төгрөг буюу 5.0 хувийн биелэлттэй байна. Үлдэгдэл төлбөр болох 1,900.0 сая төгрөгийг 2019 оны 9 дүгээр сард барагдуулахаар СЯ-тай тооцоо нийлж, эргэн төлөлтийн хуваарь гаргасан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Урьдчилж гарсан зардал

3.1.1 Илрүүлэлт:

Тус сан тайлант онд нийт техник үйлчилгээний хэлтсийн барилгын засварын ажилд нийт 397.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 278.0 сая төгрөгийг зарцуулсан боловч урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т заасан “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, аудитын “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Шийдвэрлэсэн нь:

НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-г баримтлан ажиллаж, 278.0 сая төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгэх талаар зөвлөмж өгөх.

3.1.3 Эрсдэл

